



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 18/284

Мөрөн сум

Эвент, арга хэмжээний хугацааг
тогтмолжуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 18.2.3, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн 324 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 04 дүгээр сарын 27-ны XII хуралдааны 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалыг эдийн засгийн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил”, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас “Хөвсгөлд зочлох жил-2023” болгон зарласантай холбогдуулан аймгийн хэмжээнд зохион байгуулагдах аялал жуулчлалын эвент арга хэмжээний жагсаалт болон хугацааг хавсралтаар баталсугай.

2. Аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах, зохион байгуулагдах хугацааг тогтмолжуулах, олон улсын болон үндэсний хэмжээнд сурталчлах зорилгоор батлагдсан хугацаанд жил бүр зохион байгуулсугай.

3. Сум болон хувийн хэвшил зохион байгуулдаг бусад арга хэмжээнүүдийн хугацааг тогтмолжуулж жил бүрийн тогтсон хугацаанд зохион байгуулах шийдвэр гаргаж ажиллахыг сумдын Засаг дарга, зохион байгуулагчидад даалгасугай.

4. Эвент арга хэмжээнүүдийг олон нийтэд сурталчлан, хөтөлбөрийн дагуу зохион байгуулж, хамтран ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар (П.Мөнхжаргал), Соёл урлагын газар (Л.Батцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



М.ХУЯГБААТАР

Захирамж-2023

6717010583

Аймгийн Засаг даргын 2023 оны
05 дугаар сарын 29 ний өдрийн А/284 дүгээр
захирамжийн хавсралт

ХӨВСГӨЛД ЗОЧЛОХ ЖИЛИЙН ХҮРЭЭД ЗОХИОН
БАЙГУУЛАГДАХ ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЦАГАЛБАР

№	Эвентийн нэр	Зохион байгуулагдах газрын байршил	Ерөнхий зохион байгуулагч	Хугацаа
1	Хөх сувд мөсний баяр	Хатгал тосгон	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, аймгийн Засаг даргын тамгын газар	2023 оны 03 дугаар сарын 02-04 өдрүүдэд
2	Цаа, цасны баяр	Цагааннуур сум	Аймгийн Соёл урлагын газар, Цагааннуур сумын Засаг даргын Тамгын газар	2023 оны 03 дугаар сарын 05-06 өдрүүдэд
3	Сарлаг наадам	Хатгал тосгон Хасагийн хаяа	Аймгийн Засаг даргын Тамгын газар, Алаг-Эрдэнэ сумын Засаг даргын Тамгын газар,	2023 оны 07 дугаар сарын 19-20 өдрүүдэд
4	Алунгоо эхийн сургаалийн баяр	Чандмань-Өндөр сум, Ариг голын хөвөө	Чандмань-Өндөр сумын Засаг даргын Тамгын газар,	2023 оны 07 дугаар сарын 27-29 өдрүүдэд, 4 жилд нэг удаа зохион байгуулагдана.
5	"Тэсийн голын нүүдэлчид" өв соёлын наадам	Цагаан-Уул сум Тэсийн голын хөвөө	Аймгийн Соёл урлагын газар, Цагаан-Уул, Цэцэрлэг сумын Засаг даргын Тамгын газар	2023 оны 08 дугаар сарын 06-08 өдрүүдэд 4 жилд нэг удаа зохион байгуулагдана.
6	Даль цэцэглэх цагаар хаврын баяр	Эрдэнэбулган сум	Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар	2023 оны 05 дугаар сарын 13-ний өдөр
7	Монгол бөхийн баяр	Цагаан-Үүр сум, Уялган гол	Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газар	2023 оны 07 дугаар сарын 21-22 өдрүүдэд
8	Сэрүүн сайхан хангай хангийн бүсийн уртын дууны наадам	Хөвсгөл аймгийн Жаргалант суманд	Аймгийн Соёл урлагын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	2023 оны 08 дугаар сарын 05-06 өдрүүдэд. 2 жилд нэг удаа зохион байгуулагдана.
9	Цаатан фестиваль	Хатгал тосгон, Жанхайн цагаан эрэг	Монтрейвэл ХХК Далай тур жуулчны бааз	2023 оны 07 дугаар сарын 06-07 өдрүүдэд
10	Хоёр нарны хооронд марафон гүйлтийн тэмцээн	Алаг-Эрдэнэ сум Хатгал тосгон, Жанхай	Тойлогт жуулчны бааз	2023 оны 08 дугаар сарын 05-12 өдрүүдэд
11	Мөсний загасчлалын Хөвсгөлийн цом олон Улсын тэмцээн	Ханх сум, Хороо голын адаг	Саяан-Радан ХХК	2024 оны 03 дугаар сарын 15-18 өдрүүдэд